



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
Сэтгэмж цогцолбор сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 61,000 (жаран нэгэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн, алдаатай бүртгэлийг залруулахыг нийслэлийн Ерөнхий боловсролын Сэтгэмж цогцолбор сургууль (О.Мөнхзаяа)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн Ерөнхий боловсролын Сэтгэмж цогцолбор сургууль (О.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500087

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн
А/27 дугаар тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сэтгэмж цогцолбор сургууль

№	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
								Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Боловсролын эдийн засаг ном		2011.11.24	2011.11.24	дунд	ш	1	35,000	35,000	22,750.26	12,249.74	Тавилга, эд хогшил	Ном сурах бичиг
2	СӨБ БДБ-ын эрх зүйн эмхэтгэл		2011.11.25	2011.11.25	дунд	ш	1	26,000	26,000	16,900.26	9,099.74		
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн									61,000	39,650.52	21,349.48		